МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

“ОРХОНЫ ХӨНДИЙД ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот, 2022 он

“ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Улсын Их Хурлын тогтоолын төслийн /цаашид “Улсын Их Хурлын тогтоолын төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийсэн.

1. Улсын Их Хурлын тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Улсын Их Хурлын тогтоолын төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн үр нөлөөг тогтоохын тулд үндсэн шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:
1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Харилцан уялдаа зэрэг болно.

ХОЁР. ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ:

Хууль тогтоомжийн тухай хууль

2.3.“Зорилгод хүрэх байдал” нь тухайн хуулийн төслөөр тавьж байгаа зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судалдаг шалгуур үзүүлэлт юм. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээнүүд нь хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлэхэд ашиглана.

4.5.“Зорилгод дүн шинжилгээ хийх" гэсэн шалгах хэрэгслээр хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээ тухайн хуулийн төсөлд тавьсан зорилгыг биелүүлэхэд чиглэсэн эсэх, зорилгод хүрэх байдалд дүн шинжилгээ хийх бөгөөд ийнхүү дүн шинжилгээ хийхдээ дараах зүйлийг анхаарна:

4.5.1.салбарын мэргэжилтнүүдтэй уулзалт, зөвлөгөөн хийх, тухайн асуудалтай холбоотой ном, хэвлэл, судалгааны материал зэргийг ашиглана.

4.5.2.хуулийн төсөлд зорилгод хүрэхэд чиглэсэн хэд хэдэн зохицуулалт, арга хэмжээг тусгасан бол арга хэмжээ, зохицуулалт бүрт дүн шинжилгээ хийж, тэдгээрийн зорилгод хүрэх боломжийг харьцуулна.

4.5.3.хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон зорилго, түүнийг батлан гаргах хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон тохиолдолд хуулийн төсөлд энэ талаар хэрхэн тусгасан талаар харьцуулан бичиж, тухайн зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой байна уу, хуулийн төсөлд боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байна уу гэдэгт дүн шинжилгээ хийж харьцуулна.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн заалтад тусгагдсан зохицуулалтыг судалж үзсэн болно.

Эдгээр зохицуулалт нь тогтоолын төслийн үзэл баримтлалтай уялдаж байгаа эсэх нь энэхүү шалгуур үзүүлэлтэд чухал ач холбогдолтой гэж үзлээ.

“Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж**,** Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хот, тосгон нь засаг захиргааны хувьд оршин байгаа тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэгт харьяалагдана.” гэж заасан. Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад хотыг шинээр байгуулах болон татан буулгах, нүүлгэн шилжүүлэх тухай шийдвэр гаргах бүрэн эрхийг Монгол Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа -2050” баримт бичгийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан зорилт 8.2.-ын I үе шатны 8.2.3-т “Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож, техник эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ” гэж, II үе шатны 8.2.3-т “Шинэ нийслэлд төрийн захиргааны болон зарим нийгмийн

үйлчилгээний байгууллагуудыг үе шаттайгаар нүүлгэх ажлуудыг эхлүүлсэн байна”, III үе шатны 8.2.2-т “Шинэ нийслэлийг ЮНЕСКО-д бүртгэлтэй соёлын бүтээлч хот болгоно” гэж тусгасан.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хавсралт 3.7.5-д “Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна”, Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 дүгээр хавсралт 3.6.6-д “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийх” зорилтуудыг тус тус дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассемблэйгаар 2015 онд “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030”-ыг баталж, ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих буюу хот, суурин газруудыг нийт иргэдэд зориулж аюулгүй, даван туулах чадвар сайтай, тогтвортой болгох тухай 11 дүгээр зорилтыг дэвшүүлсэн билээ. Энэхүү агуулгад тусгагдсаны дагуу хотжилтыг тогтвортой хөгжлийн зорилтуудын харилцан уялдах боломж хэлбэрээр хангах, хөгжлийн багаж, хөдөлгөх хүч болгохын үүднээс 2016 онд “НҮБ-ХАБИТАТ III их хурал”-аас баталсан “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлэхэд гишүүн улс орнуудын Засгийн газрууд анхаарч хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Мөн Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 17/12 дугаар зөвлөмжийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын Засгийн газарт: “Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, эрүүл, аюулгүй, газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү дагуул хот, суурьшлын шинэ бүс байгуулж тэлэх, чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих” гэж тусгагдсан байна.

Монгол Улсад хотжих үйл явц өнгөрсөн зууны хоёрдугаар хагаст хурдацтай өрнөж, үүнээс хойш өнөөг хүртэл нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувь өссөөр байна. Монгол улсын Үндэсний статистикийн хорооны 2022 оны мэдээгээр Монгол Улсын нийт хүн ам 3,3 сая бөгөөд үүнээс 2,2 сая хүн ам буюу 67% нь хот суурин газарт, 1,4 сая хүн ам буюу Монгол Улсын нийт хүн амын 45% нь Улаанбаатар хотод амьдарч байна. 1990 онд манай улсын нийт хүн амын 55.8 хувь нь хотын хүн ам байсантай харьцуулахад энэ үзүүлэлт нэмэгдсэн байна. Түүнчлэн Улаанбаатар хотод манай улсын их дээд сургуулиудын 88.5 хувь нь байршиж, түүнд нийт оюутан сурагчдын 95.3 хувь нь суралцаж байгаа төдийгүй Монгол Улсын эдийн засгийн идэвхтэй хүн амын 39.7 хувь нь төвлөрсөн байна.

Манай улсын хувьд Улаанбаатар хотод хүн амын хэт төвлөрөл үүссэн, бусад бүсүүдэд хэт сарнилттай байгааг илтгэн харуулж байна. Энэ нь тухайн бүс нутгуудад төрөл бүрийн хүндрэл, бэрхшээлийг үүсгэж байна. Тухайлбал, Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй хүрээлэн буй орчны бохирдлоос сэргийлэх арга хэмжээний цар хүрээ нь шилжин ирж суурьшиж буй иргэдийн тоо, гэр хорооллын өсөлтийн хурдыг гүйцэж чадахгүй байгаагаас болж орчны бохирдол нэмэгдсээр байна. Үүнээс шалтгаалан тус хотын төсөвт эрүүл мэндийн зардлаас гадна

нийгмийн халамж, үйлчилгээний зардал гэх мэт төрөл бүрийн зардлуудын дарамт нэмэгдэж байна.

ГУРАВ. ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

4.7.“Ойлгомжтой байдлыг шалгах” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томьёологдсон эсэхийг шалгаж тогтооно. Үүнд:

4.7.1.тухайн хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс санал авч, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх;

4.7.2.хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэх.

Шалгуур үзүүлэлт сонгосон шалтгаан:

Тогтоолын төслийн зохицуулалтыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлнө. Тогтоолын төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд ойлгоход хялбараар томьёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 30, 35, 36 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Мөн тогтоолын төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, дүн шинжилгээ хийсэн болно.

Тогтоолын төсөл нь тогтоолын гарчиг, тэмдэглэх хэсэг, тогтоох хэсэг гэсэн бүтэцтэй байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

ДӨРӨВ. ХАРИЛЦАН УЯЛДАА

2.8.“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгана.

3.3.“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг шалгах тохиолдолд хуулийн төслийн тодорхой зүйл, заалтыг бус хуулийн төслийг бүхэлд нь шалгана. Учир нь “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн бусад хуультай нийцэх байдлыг шалгадаг.

4.10.“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгах хэрэгслийн хүрээнд дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтооно:

4.10.1.хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;

4.10.2.хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;

4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;

4.10.4.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;

4.10.5.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;

4.10.6.хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;

4.10.7.хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;

4.10.8.хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;

4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;

4.10.10.татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;

4.10.11.тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;

4.10.12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;

4.10.13.хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;

4.10.14.хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;

4.10.15.хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;

4.10.16.хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн талаар аргачлалын 4.10 дахь заалтад заасан шалгах асуултад хариулах байдлаар үнэлгээг хийлээ.

№	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1.	хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм	Шаардлага хангасан
2.	хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	-	Улсын Их Хурлын тогтоолын төсөлд асуултад дурдсан хэсэг байхгүй болно.
3.	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	-	Улсын Их Хурлын тогтоолын төсөлд асуултад дурдсан хэсэг байхгүй болно.
4.	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Нийцэж байна.
5.	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Давхардсан заалт зохицуулалт байхгүй.
6.	хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	Тогтоолын төслийн 2 дахь заалтад хэрэгжүүлэх этгээдийг тусгасан
7.	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	
8.	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй
9.	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй
10.	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй
11.	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй
12.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчил илрээгүй.
13.	хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	-	Тогтоолын төслийн зохицуулалтад хамаарахгүй байна.
14.	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Тогтоолын төслийн зохицуулалтад хамаарахгүй байна.
15.	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Шууд хамааралтай зохицуулалт байхгүй.
16.	хуулийн төсөлд тусгасан хориглосон	Үгүй	Хууль тогтоомжийн тухай

	хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.		хуулийн 35.1-д “Монгол Улсын Их Хурлын тогтоол /цаашид “Тогтоол” гэх/-ын төсөл дараах шаардлагыг хангасан байна:”, 35.1.3-т “хариуцлагын хэм хэмжээ заахгүй байх.” гэж заасан.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд тогтоолын төслийн зүйл заалт хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн зохицуулалт байхгүй байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

Энэхүү төслийн үр нөлөө тооцох үнэлгээг Барилга хот байгуулалтын яамнаас боловсруулсан “**Орхоны хөндийд хот байгуулах тухай**” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал, тогтоолын төслийн хүрээнд хийлээ. Үнэлгээнд тогтоолын төсөл, үзэл баримтлалаас гадна тогтоолын төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд зэрэг материалыг ашигласан болно.

Тогтоолын төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, тогтоолын төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэхийг аргачлалд заасны дагуу хийсэн үнэлгээг нэгтгэн дараах дүгнэлт хийж, зөвлөмжийг боловсруулсан болно.

“Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үр нөлөөг Зорилгод хүрэх байдал, Ойлгомжтой байдал, Харилцан уялдаа тооцох гэсэн шалгууруудаар ерөнхийд нь үнэлэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн хуулийн төсөлд тавигдах шаардлагыг хангасан гэж дүгнэхээр байна. Үүнийг шалгуур тус бүрээр нарийвчлан авч үзвэл:

№	Шалгуур	Дүгнэлт
1.	Зорилгод хүрэх байдал	Тогтоолын төслийн тогтоох хэсэгт Хот байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавихаар заасан нь тогтоолын төслийн үзэл баримтлалаар тавьсан зорилгыг биелүүлэх боломжтой байна гэж үзсэн.
2.	Ойлгомжтой байдал	Тогтоолын төсөл нь тогтоолын гарчиг, тэмдэглэх хэсэг, тогтоох хэсэг гэсэн бүтэцтэй байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан гэж үзсэн.
3.	Харилцан уялдаа	Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төсөл нь зүйл заалт хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн зохицуулалт

		агуулаагүй, хуульд заасан шаардлагыг хангасан гэж үзсэн.

<u>ЗӨВЛӨМЖ ӨГӨХ</u>

Монгол Улсын Их Хурлын “**Орхоны хөндийд хот байгуулах тухай**” тогтоолын төсөл нь зорилгодоо хүрэх боломжтой, тогтоолын төслийг дагаж мөрдөхөд ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байх тул батлуулах боломжтой гэж үзэж байна.

---o0o---